



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/56

Хөхбүрд

Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын ажлыг яаралтай  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Гамшгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны халдварт боом өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 29-ний дотор шуурхай зохион байгуулж, дүн мэдээг долоо хоног тутам аймгийн мал эмнэлэгийн газарт мэдээлж ажиллахыг Мал эмнэлгийн тас (Ж.Ёндонпил)-т даалгасугай.

2. Дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, ажлын явц гүйцэтгэлд хяналт тавьж дүн мэдээг сумын онцгой комиссын хуралдаанд танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаанч (Ж.Ёндонпил)-д үүрэг болгосугай.

3. Мал, амьтны халдварт Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах Малын халдварт зооноз “Боом” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлын хэсгийг хавсралтаас, баталсугай.

4. Мал амьтныг бэлэн байлгаж товлосон хугацаанд бүрэн хамруулж, малыг барьж бэхлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангахыг малчид, мал бүхий иргэдэд үүрэг болгосугай.

5. Малчин мал бүхий иргэний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, шаардлагатай зөвлөмж мэдээллээр ханган ажиллахыг багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн тасаг, аж ахуйн нэгжүүдийн захирлуудад тус тус даалгасугай.

6. Мал, амьтны халдварт Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтад шаардлагатай 180,642 (Нэг зуун наян мянга зургаан зуун дөчин

хоёр) төгрөгийг Гамшгаас хамгаалах зардлаас санхүүжүүлхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Л.Алимаа)-д зөвшөөрсүгэй.

8.Дээрх ажлын хэсгийн аюулгүй байдлыг хангаж хэв журам сахиулж ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч цагдаагын ахлах дэслэгч (С.Дашдондов), цагдаагийн дэд ахлагч (Р.Содном), Цагдаагийн ахлах дэслэгч (Д.Азбаяр) нарт даалгасугай.

9.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, захирамжийн заалтуудыг хэрэгжүүлээгүй зөрчил гаргасан малчид, иргэдийг холбогдох хууль журмын дагуу арга хэмжээ авч ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Гансүх)-д даалгасугай.

ДАРГА  Т.БЯМБАДОРЖ







Засаг даргын.....оны дугаар сарын.....-ны  
өдрийн.... дугаар захирамжийн хавсралт

**МАЛЫН ХАЛДВАРТ БООМ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ**

**Мэргэн 4 дүгээр баг**

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Жамъяндагва (Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч)

Гишүүд: Ё.Дамдинпүрэв (Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга)

Л.Сэргэлэн (Асгамба малын эмч)

Р.Энхбат (жолооч)

Н.Мөнх-Эрдэнэ (Уранхайрхан 2 дугаар багийн хүний эмч)

Б.Пүрэвдорж (Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан)

П.Сүхдалай (Соёлын төвийн өвийн ажилтан)

А.Баасанбат (Ерөнхий боловсролын сургуулийн Хоол зүйч)

М.Ганбаатар (Байгаль хамгаалагч)

П.Ганбаатар (Ерөнхий боловсролын сургуулийн сантехникч)

О.Бат-Эрдэнэ (Ерөнхий боловсролын сургуулийн нярав)

Баярхүү (Ерөнхий боловсролын физикийн багш)

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_